




УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ᠤᠪᠪᠤ ᠠᠶᠢᠮᠭᠢᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠭᠠᠮ ᠡᠳᠢᠶᠢᠨ
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

УВС АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2019/12



**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙДАЛ**

**12 сар
2019**

Улаангом хот

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ХААНААС АВАХ ВЭ?

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/


 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	4
Статистик мэдээллийн өнгө, таних тэмдэг	5
Хэрэглэгчдэд лавлагаа	7
Товч танилцуулга	8
Үндсэн үзүүлэлт	53
III. Хүн ам	56
IV.Хөдөлмөр	57
VI. Нийгмийн даатгал, халамж	60
VII.Боловсрол	62
VIII. Эрүүл мэнд	65
X. Соёл, урлаг	68
XI. Байгаль орчин.....	69
XII. Гэмт хэрэг.....	70
XIV.Мөнгө, зээл	72
XV.Төрийн санхүү	72
XVI.Гадаад худалдаа	74
XVII. Үнэ	76
XVIII.Хөдөө аж ахуй	79
XIX. Аж үйлдвэр... ..	90
Хүн ам, малын тоо багаар	93

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

4. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд танилцуулга дээрх QR кодыг ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг uvs.nso.mn сайтаас татан авч ашиглаж болно.



Үндэсний статистикийн хорооны даргын
2013 оны 12 сарын 06 өдрийн 113-т тоот
тушаалын гуравдугаар хавсралт

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ, ТАНИХ ТЭМДЭГ

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэбийн өнгө R/G/B	Хэвлэлийн өнгө S/M/Y/K
1		Засаг захиргаа, нутаг дэвсгэр	Шар	255/212/0	0/15/100/0
2		Сонгууль	Шар	255/212/0	0/15/100/0
3		Хүн ам	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
4		Хөдөлмөр	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
5		Хүн амын амьжиргаа	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
6		Нийгмийн даатгал, халамж	Улаан	217/31/61	10/100/80/0
7		Боловсрол, шинжлэх ухаан	Шар	255/212/0	0/15/100/0
8		Эрүүл мэнд	Цайвар ногоон	128/195/66	55/0/100/0
9		Хүний хөгжил	Улаан	217/31/61	10/100/80/0
10		Соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спорт	Шар	255/212/0	0/15/100/0
11		Байгаль орчин	Ногоон	14/178/76	80/0/100/0
12		Гэмт хэрэг	Улаан	217/31/61	10/100/80/0

Д/д	Таних тэмдэг	Мэдээллийн нэр	Өнгө	Вэб-д R/G/B	Хэвлэлд S/M/Y/K
13		Үндэсний тооцоо	Хөх	23/71/158	100/85/0/0
14		Мөнгө, банк, даатгал	Хөх	23/71/158	100/85/0/0
15		Төрийн санхүү	Хөх	23/71/158	100/85/0/0
16		Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа	Хөх	23/71/158	100/85/0/0
17		Үнэ	Хөх	23/71/158	100/85/0/0
18		Хөдөө аж ахуй	Улбар шар	248/165/26	0/40/100/0
19		Аж үйлдвэр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
20		Тээвэр, харилцаа, холбоо	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
21		Худалдаа, үйлчилгээ	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
22		Барилга, орон сууц, нийтийн аж ахуй	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
23		Бизнес регистр	Цэнхэр	117/190/223	50/10/0/0
24		Дэлхийн улс орнуудын хөгжил	Хөх цэнхэр	64/133/197	75/40/0/0

Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг uvs.nso.mn хаягаар орох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын II байранд байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- ✚ Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- ✚ Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- ✚ Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- ✚ 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- ✚ Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- ✚ Судалгааны үр дүнгүүд
- ✚ 2013-2018 оны ХАА-н салбарын танилцуулга,
- ✚ 2013 -2018 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- ✚ 2013-2018 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- ✚ 2013-2018 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- ✚ Аймгийн ДНБ үйлдвэрлэлт-2014 онд
- ✚ 2016 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2017 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ 2018 оны сар бүрийн танилцуулгууд
- ✚ Хүн амын хүрээлэн буй орчны танилцуулга
- ✚ Статистикийн эмхэтгэлүүд
- ✚ Статистикийн өврийн дэвтрүүд
- ✚ 2019 оны сар бүрийн танилцуулгууд

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг: uvs.nso.mn www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn/ албаны хаяг /

Утас: 70452322,70453316, 99906004, 89610610, 95059079, 99760175,94000570






III. ХҮН АМ

3.1 Хүн амын тоо

Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас үндэслэн гаргасан хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 41.6 мянган эрэгтэй, 41.3 мянган эмэгтэй нийт 82.9 мянгад хүрч өмнөх оноос нийт хүн амын тоо 0.4 хувиар буюу 0.7 мянган хүнээр буурсан байна.

Зураг 3.1 Хүн амын тоо, мян.хүнээр, жилийн дундаж өсөлтийн хувь, онуудаар




Зураг 3.2 Хүн амын тоо сумуудаар, нийт хүн амд эзлэх хувиар




Улаангом, Зүүнговь сумдын хүн амын тоо 0.2 хувиар өсч, бусад сумдын хүн амын тоо өнгөрсөн оноос 0.3 – 4.4 хувиар буурсан байна.

Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Ховд, Зүүнхангай сумдын хүн амын тоо аймгийн дунджаас 0 – 0.5 пунктээр бага, бусад сумдын хүн амын бууралтын хувь аймгийн дунджаас 0.2 – 3.6 пунктээр их байна.

Зураг 3.3 Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, сумдаар



Зураг 3.4 Хүн амын нас хүйсийн суварга, 2019 он




Хүн амын 33.8 хувийг /28.0 мянга/ 0-14 насны хүүхэд/ 60.9 хувийг /50.5 мянга/ хөдөлмөрийн насны хүн ам, 5.4 хувийг /4.4 мянга/ хөдөлмөрийн нас хэтэрсэн хүмүүс эзэлж 2018 онтой харьцуулахад хүүхдийн эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүн амын эзлэх хувь 0.2, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.1 пунктээр буурсан байна.

Нийт хүн амын 38.2 хувь нь Улаангом суманд оршин сууж, тэдгээрийн 33.3 хувийг 0-14 насны хүн ам, 60.9 хувийг 15-60 насны, 5.7 хувийг 60-с дээш насны хүн ам эзэлж байна.

Хүн амын насыг 2019 оны 12 сарын 31-тэй харьцуулж бүтэн насаар бодсон бөгөөд 70 ба түүнээс дээш насны 1775 өндөр настан, үүний 1153 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 103 настай 1 эмэгтэй хүн Бөхмөрөн сумын 2-р багт (Хар алтат) амьдарч байна.

21654 өрх байгаа нь өнгөрсөн оноос 1.8 хувиар буюу 393 өрхөөр буурч, нэг өрхөд дунджаар 3.8 хүн амьдарч байна.

Зураг 3.5 Өрхийн тоо, нэг өрхөд ноогдох хүний тоо, онуудаар




Нийт өрхийн 57.9 хувь нь аймаг, сумын төвд, 42.1 хувь нь хөдөөд амьдарч байна. Ам бүлийн тоогоор авч үзвэл нийт өрхийн 14.0 хувь нь нэг ам бүлтэй, 67.4 хувь нь 2-5 ам бүлтэй, 18.5 хувь нь 6-9 ам бүлтэй, 0.1 хувь нь арав ба түүнээс дээш ам бүлтэй өрхүүд байна.

3.2 Өрх, өрхийн зарим үзүүлэлт


2019 оны байдлаар бүтэн өнчин хүүхэд 73, хагас өнчин хүүхэд 1462 хүүхэд байна. Өнгөрсөн онтой харьцуулахад бүтэн өнчин хүүхдийн тоо 6.4 хувиар буурч, хагас өнчин хүүхдийн тоо 1.6 хувиар өссөн байна.

Зураг 3.6 Бүтэн болон хагас өнчин хүүхдийн тоо, онуудаар




Аймгийн хэмжээнд өрх толгойлсон 2437 эцэг /эх/ байгаагийн 62.5 хувь нь 3 хүртлэх гишүүнтэй, 30.7 хувь нь 3-5 хүртлэх гишүүнтэй, 6.8 хувь нь 6 түүнээс дээш гишүүнтэй өрх эзэлж байна. Өрх толгойлсон эцэг эхийн тоо өмнөх оноос 4.7 хувиар өссөн байна.

Зураг 3.7 Өрх толгойлсон ганц бие хүний тоо, онуудаар




Нийт өрх толгойлсон 1975 эмэгтэй байгаагийн 62.4 хувь нь 3 хүртэл гишүүнтэй, 31.2 хувь нь 3-5 гишүүнтэй, 6,4 хувь нь 6 ба түүнээс дээш гишүүнтэй өрх байна. Харин 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх,эцэг 914, үүнээс өрх толгойлсон эх нь 754 байна.

Зураг 3.8 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрхийн гишүүдийн тоогоор, 2019 он



Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо энэ оны урьдчилсан дүнгээр 4682 болж, өмнөх оноос 0.1 (2.8%) мянган хүнээр өсчээ.

Зураг 3.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо




3.3 Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт

Иргэний бүртгэлийн мэдээгээр 2019 онд 1911 эхээс 2000 хүүхэд төрж бүртгүүлсэн нь Өмнөх оноос төрсөн эхийн тоо 3.7 хувиар буурч, хүүхдийн тоо өмнөх оны түвшинд байна.

450 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 9 хүнээр буюу 1.9 хувиар буурч, цэвэр өсөлт 1550 болж 0.6 хувиар өссөн байна.

Зураг 3.10. Хүн амын төрөлт, нас баралт, онуудаар



** Иргэний бүртгэлийн мэдээлэлээр


Төрөх үеийн хүйсийн харьцаа 103.3, нийт төрсөн хүүхдийн 50.8 хувийг эрэгтэй хүүхэд, 49.2 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна.

Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээгээр 2019 онд 2000 хүүхэд төрж, 450 хүн нас барсан, эмнэлэгийн мэдээгээр 1910 хүүхэд төрж, 432 хүн нас барсан байгаа бөгөөд бусад газраас ирж төрсөн, нас барсан хүний тоогоор болон бүртгэл он дамжиж хийгддэгтэй холбоотойгоор зөрүү үүссэн байна.

588 хосууд гэрлэлтээ батлуулж, 29 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад гэрлэлтээ батлуулсан хосын тоо 4.1 хувиар өсч, цуцлуулсан хосын тоо 38.3 хувиар буурсан байна.

47 хүүхэд үрчлэгдсэн нь өнгөрсөн оноос 2.2 хувиар өссөн байна.

Зураг 3.11. Хүн амын гэрлэлт, цуцлалт, онуудаар



** Иргэний бүртгэлийн мэдээлэлээр


Эрүүл мэндийн газрын мэдээллээр аймгийн хэмжээнд 2019 онд 1892 эх амаржиж, 1910 хүүхэд төрж, мөн нас баралт 432 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 4 (0.2%), төрсөн хүүхэд 2 (0.1%)-оор, нас баралт 25 (5.5%) -оор тус тус буурчээ. 1000 хүнд ноогдох төрөлт 21.2, нас баралт 4.7, цэвэр өсөлт 16.5 болов.

Өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ноогдох нас баралт 0.4 пунктээр, төрөлт 0.1 тус тус буурч, цэвэр өсөлт 0.2 пунктээр өсчээ.

Зураг 3.12 Төрсөн хүүхдийн тоо, онуудаар



Зураг 3.13 1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эцэст



1000 хүн амд ноогдох төрөлтийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 1.7 пунктээр, нас баралтын тоо 0.4 пунктээр тус тус буурсан байна.

Гэрийн төрөлт 11 гарч өмнөх оноос 2 төрөлтөөр өсчээ. Нийт нас баралтын 15.3 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурсан байна.




IV. ХӨДӨЛМӨР

4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Энэ онд аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 701 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 105 (17.6 %) хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 352 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 50.2 хувийг эзэлж байна.

2019 онд бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 84 (10.7 %) ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 15 (2.1 %) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.


Зураг 4.1 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 5 жилээр



Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт энэ онд 3731 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 1651 иргэн ажилд зуучлагдан орж, 3730 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 14.3 хувь нь 15-24 насны, 36.8 хувь нь 25-34 насны, 26.8 хувь нь 35-44 насны, 18.4 хувь нь 45-54 насны, 3.4 хувь нь 55-59 насны, 0.3 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 25.0 хувь нь дээд, 12.7 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 53.1 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 9.2 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс байна.

Зураг 4.2 Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр




2019 онд 1394 ажлын байрны захиалга ирснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 157 (12.7%) –оор өссөн байна.

Зураг 4.3 Ажлын байрны захиалга, ажилд орсон хүний тоо




Ажлын байрны захиалгыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл: барилгын салбар 31.1 % , үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 22.9 % , боловсролын салбар 13.3 % , бусад салбар 32.7 % эзэлж байна.

Зураг 4.4 Ажлын байрны захиалга салбарын ангиллаар , хувь




Ажлын байрны захиалгын 23.5 хувь нь мэргэжилтэний, 5.5 хувь нь техникч болон туслах дэд мэргэжилтэний, 5.9 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтны, 20.2 хувь нь үйлдвэрлэл, барилгын ажилтны, 20.7 хувь нь энгийн ажил мэргэжлийн, 24.2 нь бусад албан тушаалын захиалга байлаа.

Зураг 4.5 Ажлын байрны захиалгын эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар



Байнгын болон түр, улирлын чанартай ажлын байранд 1927 хүн ажилд орсны 29 хувь барилгын салбарт, 49 хувь нь үйлчилгээний бусад салбарт, 14 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 2 хувь нь уул уурхайн салбарт, 6 хувь нь боловсролын салбарт тус тус ажилд орсон байна.

Зураг 4.6 Ажлын шинэ байранд ажилд орсон хүний эзлэх хувь, салбараар



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Бүртгэлтэй ажилгүй иргэн: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр

эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.



VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого онд 21354.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4833.3 (29.3%) сая төгрөгөөр өсч, сангийн зарлага 54893.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7268.6 (15.3%) сая төгрөгөөр өсчээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 7268.6 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 5743.2 (14.0%) сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.


Зураг 6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, оны эцэст, сая төгрөг



Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг Бөхмөрөн сум 0.8 хувиар тасалсан бол бусад сумууд 0.7 – 30.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сан 919.5 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 288.1 (45.6%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт авлагын 23.3 хувийг төсөвт байгууллагын өглөг эзэлж байна.

Зураг 6.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, сая төгрөг




Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэвэрийн даатгалын сангийн орлого 3281.9 (30.6%), ҮОМШӨ –ний даатгалын сангийн орлого 290.9 (31%), ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 79.2 (30.6%), тэтгэмжийн даатгалын сангийн орлого 371.8 (30.9%) сая төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг 6.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, сая төгрөг



Өмнөх оны мөн үеэс тэтгэвэрийн даатгалын сангийн зарлага 5743.2 (14.0%), эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 1228.2 (27.3%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 307.6 (17.0%) , үйлдвэрийн осол мэргэжлээс шатгаалах өвчний даатгалын сангийн зарлага 0.4 (0.4%) сая төгрөгөөр тус тус өсч, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 10.7 (3.5%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 6.4 Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Нийгмийн халамжийн сангаас энэ онд 40.2 мянган хүнд 14518.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс олгосон тэтгэвэр тэтгэмж 30.9 (0.2 %) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ онд 1.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 151 (8.1%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр 394.2 (12.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 6.5 Халамжийн сангийн зарцуулалт, жил бүрийн эцэст, сая төгрөг



2019 онд хэрэгжиж эхэлсэн цалинтай ээж хөтөлбөрт 4852 хүн хамрагдаж 2735.3 сая, өрх толгойлсон эцэг, эх хөтөлбөрт 192 хүн хамрагдаж 266.4 сая төгрөгийг олгосон байна.

Асрамжийн газар нийт 18 хүн асруулж байгаа бөгөөд 12 эмэгтэй байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 198.1 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 19.4 (10.9%) сая төгрөгөөр өсч, асруулагч 1 (5.9%) хүнээр өссөн байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР


НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.

VII. БОЛОВСРОЛ


2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 709 бүлэгт 17.9 мянган хүүхэд суралцаж байгаа ба бүлгийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 – аар, суралцагчдын тоо өмнөх оноос 1.7 хувиар, өмнөх 3 жилийн дунджаас 2.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 7.1 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо




2019-2020 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролд 2903 хүүхэд, суурь боловсролд 5820 хүүхэд, бага боловсролд 9237 хүүхэд суралцаж байна. Бүрэн дунд боловсролд суралцагчид 5.1 хувиар буурч, бага боловсролд суралцагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 3.8 хувиар суурь боловсролд суралцагчид 4.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 7.2 Ерөнхий боловсролын сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсролд суралцагчид




Шинээр 1-р ангийн 75 бүлэгт 1942 хүүхэд элсэн орсон нь өнгөрсөн оноос 64 хүүхдээр буюу 3.2 хувиар буурч, өмнөх 3 жилийн дунджаас 2.6 хувиар өссөн байна.

Зураг 7.3 Ерөнхий боловсролын сургуульд 1 – р ангид элсэгчид




Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад 1019 үндсэн багш ажиллаж нэг багшид 18 сурагч ноогдож байгаа нь нэг багшид ногдох сурагчдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.9 %-аар өссөн байна.

Зураг 7.4 Ерөнхий боловсролын сургуульд 1 багшид ногдох сурагчдын тоо



Сургуулийн өмнөх боловсролд 2019-2020 оны хичээлийн жилд 7595 хүүхэд хамрагдаж өмнөх оноос 7.5 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 10.9 хувиар тус тус өссөн байна.


Зураг 7.5 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо



2019-2020 оны хичээлийн жилд хөдөлмөрийн дээд сургуулийн 1-р курсэд нийт өдрийн ангид 11, эчнээ ангид 6 нийт 17 оюутан элсэн орж, нийт 138 оюутан суралцаж байна. Хөдөлмөрийн дээд сургуулийн нийт суралцагчдын 67.4 хувь нь буюу 93 эмэгтэй оюутан байна. Хөдөлмөрийн дээд сургуулийг 2019 онд өдрийн ангийг 24, орой ангийг 20, эчнээ ангийг 8 нийт 52 оюутан төгссөн байна.

Улаангом коллежийн мэргэжлийн боловсролын 1-р курсэд 456 хүүхэд элсэн орж нийт 912 суралцагч, үүнээс эмэгтэй 416 оюутан суралцаж байна. Үүнээс мэргэжлийн боловсролд нийт 661 суралцагч, техникийн боловсролд 217 суралцагч, богино хугацааны сургалтанд 34 суралцагч суралцаж байна. Улаангом коллежийг 2019 онд 423 суралцагчид төгссөн байна.


Зураг 7.6 Их дээд сургууль, коллежид суралцагчдын тоо




VIII. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл энэ онд 26 гарсан ба өмнөх оны мөн үеэс 1 гаралтаар бага байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34 гарсан ба өнгөрсөн оны мөн үеэс 4 гаралтаар бага байна. 1000 амьд төрөлтөнд 13.6 нялхсын эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн 17.8 эндэгдэл ноогдож байна.

Зураг 6.1 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар




Зураг 6.2 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл



1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл Бөхмөрөн суманд 400.0, Тэс суманд 103.4, Хяргас суманд 100.0, Тариалан суманд 21.7, Улаангом суманд 13.6, аймгийн дундаж 9.0 байна.

Зураг 6.3 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин, сумаар



Зураг 6.4 1000 амьд төрөлтөд ноогдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сумаар




Энэ оны эцсийн байдлаар осол гэмтлийн улмаас 57 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 607 болсон нь өмнөх оны мөн үеэс өвчлөгчдийн тоо 9 (1.5%) – өөр, нас баралтын тоо 3 (5.6%) - аар тус тус өссөн байна. Өмнөх 4 жилийн дунджаас осол гэмтлээр өвчлөгчдийн тоо 23.3 хувиар буурч, осол гэмтлийн нас баралтын тоо 7.5 хувиар өссөн байна.

Зураг 6.5 Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тоо




Хорт хавдрын өвчлөл 196 гарч өмнөх оны мөн үеэс 30 (18.1%) – аар өсч, нас баралт 155 гарсан нь өмнөх оны мөн үеэс 5 (3.1%) – аар буурчээ.

Зураг 6.6 Хорт хавдрын өвчлөл, нас баралтын тоо



Энэ онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 627 болж өнгөрсөн оны мөн үеэс 13 (2.1%) хүнээр өсч, өмнөх 4 жилийн мөн үеийн дунджаас 89 (12.4%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 6.7 Халдварт өвчний гаралт, тоогоор




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл БЗХӨ нийт халдварт өвчний 62.8, салхинцэцэг 13.1, сүрьеэ 6.7, гар хөл амны өвчин 9.6, гепатит 2.4, бусад өвчин 5.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 6.8 Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд, хувиар, 2019 I-XII сар




10000 хүн тутмаас 90.7 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Зүүнхангай 97.7, Улаангом 123.7 нь аймгийн дунджаас 7.0 – 33.0 процентимилээр өндөр, бусад сумдад аймгийн дунджаас 8.3 – 75.3 процентимилээр бага байна.

Зураг 6.9 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчний тоо, сумаар



Зураг 6.10 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Амбулаториор 426.8 мянган хүнд үзлэг хийгдэж, 20.8 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 45.4 мянган хүнээр өсч, хэвтэн эмчлүүлэгчид 0.2 мянган хүнээр буурсан байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ЭРҮҮЛ МЭНД

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.


Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндэснийг хамруулна.



Х.Соёл


Аймгийн хөгжимт драмын театр нийт 112.1 мянган хүнд 282 тоглолтоор үйлчилсэн нь өнгөрсөн оны мөн үеэс тоглолтын тоо 21.0, үзэгчид 25.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 10.1 Тоглолтын тоо, үзэгчдийн тоо




Орон нутгийг судлах музей 4.7 мянган хүнд 5778 үзмэрээр үйлчилж, шинээр 41 үзмэрээр урын сангаа баяжуулсан нь өнгөрсөн оноос үзмэрийн тоо 0.7 хувь, шинээр нэмэгдсэн үзмэрийн тоо 5.8 дахин нэмэгдсэн байна.

Зураг 10.2 Музейн үзэгчид ба үзмэрийн тоо



Төв номын сан 43.4 мянган уншигчдад 45.9 мянган номоор үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс олгосон ном 29.1 хувиар, уншигчдын тоо 17.5 хувиар тус тус буурсан байна. Төв номын санд цахим сан хөмрөгийн 44, электрон каталогит оруулсан 589 ном байна

Зураг 10.3 Уншигчид ба уншуулсан номын тоо , мян.хүн, мян.ном



XI. БАЙГАЛЬ ОРЧИН

11.1 Цаг уурын байдал

Энэ оны 12 дугаар сард агаарын температур дунджаар Ховд, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Наранбулаг сумдад -17.9 -ээс доош хүйтэн, хөрсний гадаргын дундаж температур Зүүнговь, Сагил, Баруунтуруун, Давст суманд хамгийн хүйтэн -22.2 -оос дээш градус байжээ. Салхины хамгийн их хурд Малчин, Өндөрхангай, Цагаанхайрхан, Өлгий, Өмнөговь суманд 11 - 14 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговьд 8 өдөр байв. Малчин суманд 27 см цас орсон нь бусдаас илүү байна.

Өнгөрсөн оны мөн үеэс азотын давхар исэл 0.003 мг/м^3 -аар их байсан ба хүлцэх агууламжаас давсан хувь 1 тохиолдол гарсан байна.




XII. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

12.1 Гэмт хэргийн статистик


Энэ онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 327 болж өнгөрсөн оны мөн үеэс 5 (1.5%), өмнөх 4 жилийн дунджаас 18 (5.3)-аар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас 126 хүн гэмтэж, 334 иргэн хохирсон байна.

Зураг 12.1 Гэмт хэргийн гаралт, оны эцэст




Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 5.9 хувь, хууль бусаар тод бэлтгэх 66.7 хувь, мал хулгайлах 10.4 хувь, хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 66.7 хувь, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 0.9 хувиар өсч, тээврийн хэрэгслийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 50.0 хувь, авилгын эсрэг гэмт хэрэг 70.0 хувиар тус тус буурчээ. Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 15, согтуугаар үйлдэгдсэн 101, бүлэглэн 16, гудамж талбайд 40, гэр орон сууцанд 102 гэмт хэрэг гарсан байна.

Зураг 12.2 Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо



Гэмт хэрэг үйлдсэн 257 хүнээс 20 нь эмэгтэйчүүд, 16 нь хүүхэд байна. Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн тоо 19 (8.0%) хүнээр өсчээ. Гэмт хэргийн улмаас 618.7 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 399.8 (39.3%) сая төгрөгөөр буурчээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 65.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Зураг 12.3 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг




Нийт гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 163 тохиолдол гарч, өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд нийт 16442 зөрчил шийдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 4562 (38.4%) зөрчлөөр өссөн байна. Энэ онд 410 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж торгуулжээ.

12.2 Шүүхийн статистик

Аймгийн шүүхийн тамгын газраас ирүүлсэн мэдээллээр шүүхээр нийт 653 хэрэг шийдвэрлэжээ. Шүүхийн төрлөөр авч үзвэл эрүүгийн хэрэг 164, захиргааны хэрэг 19, иргэний хэрэг 428, давж заалдах шатны шүүхээр 42 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.


Зураг 12.4 Шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн тоо, шүүхийн төрлөөр

Увс аймгийн шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, төрлөөр



Шүүхээр ял шийтгүүлсэн нийт 182 иргэн, үүнээс хорих ял шийтгүүлсэн 40 иргэн байна.

Зураг 12.5 Ял шийтгүүлсэн хүний тоо, насны бүлгээр



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ГЭМТ ХЭРЭГ

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан; уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон; уг этгээд хэргээ илчлэн ирсэн гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Яллагдагч: МУ-ын "Эрүүгийн байцаан шийтгэх" хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ойлгоно.




XIV. МӨНГӨ, БАНК

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 191.5 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2.6 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 6.4 (3.3 %) тэрбум төгрөгөөр буурч хугацаа хэтэрсэн зээл 755.3 (40.3 %) сая төгрөгөөр өссөн байна.


8.1 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2.7 (25.4 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 14.1 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдэл 126.9 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 18.1 (16.6 %) тэрбум төгрөгөөр өссөн байна. Өмнөх 3 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 35.3 (27.8 %) тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 14.2 Нийт хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдлийн 77.0 хувь нь хугацаатай, 23.0 хувь нь хугацаагүй хадгаламж байна. Хадгаламж эзэмшигчдийн тоо 76.7 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өссөн байна.

XV ТӨРИЙН САНХҮҮ

15.1 Орон нутгийн төсвийн орлого




Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор энэ онд аймгийн төсөвт 31.2 тэрбум төгрөг оруулахаас 32.1 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 102.6 хувьтай, 805.8 (2.6%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 13.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 18.5 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 4786.2 (35.0%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 3.8 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 7.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 3980.5 (2.0 дахин) сая төгрөгөөр, аймгийн төсөвт өөрийн орлогоор 9.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 10.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 805.8 (8.2%) сая төгрөгөөр тус тус давуулан биелүүллээ. Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 5133.4 (38.5%) сая төгрөгөөр их, үүнээс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 3898.3 (2.0 дахин) сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 1235.2 (13.1%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


Энэ онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 765.3 (2.5 дахин) сая төгрөгөөр, нэмэгдсэн өртөгийн татвар 2921.6 (97.4%) сая төгрөгөөр, онцгой албан татвар 67.0 (33.5%), ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 166 (2.7 дахин), агаарын бохирдлын төлбөр 60.7 (3.2 дахин) сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

Зураг 15.1 Төсвийн орлогын бүтэц, хувиар



Аймгийн төсвийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 26.9 хувиар, өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 46.1 хувиар тус тус өссөн байна.


Зураг 15.2 Төсвийн орлогын өсөлт бууралт, онуудаар, сая төгрөг




15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 79.8 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувиар өсчээ.

Зураг 15.4 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 15.5 Төсвийн зарлагын бүтэц, хувь




Төсвийн зардлын 38.8 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 52.0 хувийг боловсрол соёлын үйл ажиллагаанд, 8.1 хувийг эрүүл мэнд, амралт, спортын үйл ажиллагаанд, 0.7 хувийг барилга хот байгуулалтанд, 0.4 хувийг хүн амын хөгжил нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд зориулан зарцуулсан байна.

15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА


Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр энэ онд 263.4 сая төгрөгийн өртэй, 87.2 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Зураг 15.6 Төсөвт байгууллагуудын өглөг, авлага

Төсөвт байгууллагуудын өглөг жил бүрийн 12 сарын эцэст, сая.төгрөг



Төсөвт байгууллагуудын авлага жил бүрийн 12 сарын эцэст, сая.төгрөг






XVI. ГАДААД ХУДАЛДАА


Энэ онд импорт 22651.1 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5503.8 (19.5 %) мянган америк доллараар буурсан байна. Гол нэрээс дурдвал цахилгаан 119045.3 мянган киловатт цаг, авто бензин 9238.0 тонн, дизель түлш 11294.5 тонн, хивэг 4287 тонн, овъёос 890 тонн, мебель тавилга 271 ширхэг, банз мод 802.5 м3 тус тус импортоор оруулсан байна.

Зураг 16.1 Нийт импорт, экспорт жил бүрийн эцэст мян.ам.доллар



Өнгөрсөн оны мөн үеэс, авто бензин 2489.7 (21.2 %) тонн, тахианы өндөгний импортын хэмжээ 109.8 (14.8 %) мянган ширхэг, дизель түлш 4634.1 (29.1 %) тонн, овъёос 265.9 (23.0 %) тонноор импорт буурсан бол банз мод 317.4 (65.4 %) м3, өнгөлгөөний тоосго 438.1 (2.5 дахин их) тонн, хиам 3.8 (8.6 дахин их) тонн, цахилгаан эрчим хүч 8036.4 (7.2 %) мян.квт.цаг, цагаан будаа 4(88.9 %) тн-оор импорт нь өссөн байна.

Энэ онд нийт экспорт 1938.1 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1610.8 (5.9 дахин) мянган америк доллараар өссөн байна. Гол нэрийг дурдвал цай 4.2 тонн, монгол гэр 3 ширхэг, брезент 32 боодол, борц 1.2 тонн, мах 462.9 тонн, чулуулгийн дээж 0.97 тонныг тус тус экспортлосон байна.



XVII. ҮНЭ

17.1 Хэрэглээний үнэ

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 238 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 12-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 8.2 хувь, оны эхнээс 8.2, өмнөх сараас 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 17.1 Хэрэглээний барааны үнэ тарифын 12-р сарын индекс, хувь

Бүлэг	2019.12/ 2018.12	2019.12/ 2018.12	2019.12/ 2019.11
ЕРӨНХИЙ ИНДЕКС	108.2	108.2	101.5
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	111.8	111.8	104.2
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	103.1	103.1	100.0
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	104.3	104.3	100.4
04. ОРОН СУУЦ, УС,ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	115.8	115.8	100.5
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	106.3	106.3	100.2
06. ЭМ ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.3	103.3	100.0
07. ТЭЭВЭР	100.9	100.9	100.4
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	99.6	99.6	100.0
09. АМРАЛТ,ЧӨЛӨӨТ ЦАГ,СОЁЛЫН БАРАА,ҮЙЛЧИЛГЭЭ	101.0	101.0	100.0
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	123.7	123.7	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТ.БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	102.5	102.5	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	105.8	105.8	101.3

Өмнөх сараас хүнсний барааны бүлгийн үнэ 4.2, хувцас бөс барааны бүлгийн үнэ 0.4, орон сууц, ус цахилгаан, түлшний бүлгийн үнэ 0.5, тээврийн бүлгийн үнэ 0.4, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 1.3 хувиар өсч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Зураг 17.1. Хэрэглээний үнийн индекс 12 сар, бүлгээр, хувь




Зураг 17.2. Сүүлийн 4 жилийн индексийг өмнөх сар, оны эхтэй харьцуулсан индекс



Сүүлийн 4 жилийн 12-р сарыг: өмнөх оны эхтэй харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2017 оны 12-р сард 9.0 хувь, хамгийн бага нь 2016 оны 12-р сард 1.0 хувийн өсөлттэй тооцогдож байна. Харин өмнөх сартай харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2019 оны 12 сард 1.5, хамгийн бага нь 2016 оны 12 сард 0.5 хувь өсч байжээ.

Зураг 17.3. Сарын инфляцийн түвшин




Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна.



Махны дундаж үнэ:

2019 оны 12 сард хонь, ямаа, үхрийн махны үнэ сарын турш тогтвортой байсан байна.

Зураг 17.4. Махны үнэ, долоо хоногоор, төрлөөр



12-р сард дунджаар 1 кг хонь, үхрийн махны үнэ 7500 төгрөг , ямааны мах 4500, 1 л шингэн сүү 1953 төгрөг, элсэн чихэр 2333 төгрөг, цагаан будаа 2500 төгрөг, бензин А-80 1900, А-92 1980, дизель түлш 2490 төгрөгийн дундаж үнэтэй байсан байна.



17.2 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 12 дугаар сард ат Өмнөговь суманд хамгийн их буюу 1.3 сая төгрөг, Завхан, Зүүнговь, Наранбулаг, Өлгий, Өндөрхангай суманд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг, соёолон үрээ Наранбулаг, Өлгий, Өмнөговь суманд хамгийн их буюу 1.0 сая төгрөг, Завхан, Тэс, Хяргас суманд хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, хязаалан шар Өлгий, Өмнөговь суманд хамгийн их буюу 1.2 сая төгрөг, Цагаанхайрхан суманд хамгийн бага буюу 750.0 мянган төгрөгийн үнэтэй байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Улаангом суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Өмнөговь суманд хамгийн бага буюу 130.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Завхан суманд хамгийн их буюу 130.0 мянган төгрөг, Малчин суманд хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 12 дугаар сард үхрийн ширний дундаж үнэ 5.0 мянган төгрөг, адууны ширний дундаж үнэ 7.0 мянган төгрөг, хонины ноостой нэхийний дундаж үнэ 2.5 мянган төгрөг, ямааны ноолууртай арьсны үнэ 30.0 мянган төгрөг байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээгээр 2019 оны 12 дугаар сард 1 тонн таваарын буудайн дундаж үнэ Баруунтуруун суманд 500.0 мянган төгрөг, 1 тонн овъёосны дундаж үнэ 700.0 мянган төгрөг байна.

Боодолтой өвсний дундаж үнэ Улаангом суманд хамгийн их буюу 7.0 мянган төгрөг, Тэс суманд хамгийн бага буюу 4.5 мянган төгрөг, 1 тонн сүрэл, задгай өвсний дундаж үнэ Баруунтуруун суманд 200.0 мянган төгрөг байна.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2015 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 238 нэр төрөл болгож 2015 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

Инфляци: Үнэ өсч тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг хэлнэ. Инфляцийн түвшинг тооцохдоо дараах томъёог ашиглана. Үүнд:

$$\text{Инфляцийн түвшин} = \frac{I_t - I_0}{I_0} * 100$$

I_t – Тайлант үеийн үнийн индекс
 I_0 – Суурь үеийн үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жинг хэлнэ.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, Ласпейресийн үнийн индексийн томъёогоор тооцож байна. Үүнд:

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

I_p^t - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
 t – Тайлант үе
 0 – Суурь үе
 p_t^i – i барааны тайлант үеийн үнэ
 p_0^i – i барааны суурь үеийн үнэ
 q_0^i - i барааны суурь үеийн худалдан авсан тоо




XVIII. ХӨДӨӨ АЖ АХУЙ

18.1 Мал аж ахуй

Малын тоо


Аймгийн хэмжээнд мал тооллогын дүнгээр 8.9 мянган малчин өрхийн 16.0 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Малчин өрхийн тоо өнгөрсөн оноос 58 өрхөөр өсч, малчдын тоо 142 хүнээр буурсан байна. 2019 оны эцэст 3279.6 мянган толгой мал үүний дотор 25.6 мянган тэмээ, 130.6 мянган адуу, 195.7 мянган үхэр, 1604.8 мянган хонь, 1322.8 мянган ямаатай болж тэмээ 0.5 (1.9%) мянга, адуу 6.8 (5.6%) мянга, үхэр 12.8 (7.0%) мянга, хонь 36.8 (2.3%) мянга, ямаа 47.3 (3.7%) мянган толгойгоор таван төрөлдөө өсч, өнгөрсөн оноос нийт малын тоо 104.3 (3.3%) мянган толгойгоор нэмэгдсэн байна.

Зураг 18.1.1 Сүүлийн 10 жилийн малын тооны өсөлт, бууралт, мянган толгой



14 сумын малын тоо өнгөрсөн оноос 0.7 – 34.7 (0.5 – 17.2 %) мянгаар өсч, Зүүнхангай, Малчин, Өндөрхангай, Сагил, Хяргас, Улаангом сумууд малаа 5 төрөл дээр өсгөсөн байна.

Зураг 18.1.2 2019 оны бүх мал, сумаар, мян.тол



Сумдыг малын тоогоор бүлэглэвэл:

- 200.0 мянгаас дээш толгой малтай сумын тоо - 6 сум Тэс 287.9, Өндөрхангай 236.9, Наранбулаг 233.1, Улаангом 216.1, Өмнөговь 211.2, Хяргас 208.4
- 100.0 – 200.0 мянган толгой малтай сумын тоо – 11 сум Сагил 187.0, Цагаанхайрхан 183.3, Зүүнхангай 178.4, Малчин 174.3, Ховд 162.9, Тариалан 150.2, Түргэн 144.6, Зүүнговь 142.5, Бөхмөрөн 140.5, Завхан 130.8, Өлгий 115.0
- 50.0 -100.0 мянган толгой малтай сумын тоо - 2 сум Давст 98.5, Баруунтуруун 78.1

Аймгийн нийт малын 8.8 хувийг эзэлж буй Тэс сум 287.9 мянган толгой малтайгаар хамгийн олон малтай, 2.4 хувийг эзэлдэг Баруунтуруун сум 78.1 мянган малтайгаар хамгийн цөөн малтай сумын тоонд орж байна.

Мал тооллогын 2019 оны дүнгээр аймгийн хэмжээнд нийт малын тоогоор Тэс сум, тэмээгээр Завхан сум, адуу, үхэр, хониор Тэс сум, ямаагаар Өндөрхангай сум тус тус тэргүүлж байна.



Нийт малын тоогоор эхний 5-д орох сумууд	Үүнээс	
	Тэмээгээр /мян.тол/	адуугаар /мян.тол/
Тэс -287.9 мян.тол	Завхан- 10.0	Тэс - 15.8
Өндөрхангай - 236.6 мян.тол	Наранбулаг - 2.9	Өндөрхангай -12.2
Наранбулаг-233.1 мян.тол	Тэс - 2.3	Улаангом - 10.9
Улаангом - 216.1 мян.тол	Өлгий - 2.2	Зүүнхангай - 10.8
Өмнөговь - 211.2 мян.тол	Өмнөговь - 1.6	Зүүнговь - 7.9
Дүнд эзлэх хувь- 36.1	Дүнд эзлэх хувь- 75.7	Дүнд эзлэх хувь- 44.1
Өсгөсөн сум- 14	Өсгөсөн сум- 10	Өсгөсөн сум- 14
Өсөлт бууралтын хувь- 103.3	Өсөлт бууралтын хувь- 101.9	Өсөлт бууралтын хувь- 105.6

Үхрээр /мян.тол//	хониор /мян.тол/	Ямаагаар /мян.тол/
Тэс - 32.2	Тэс - 159.1	Өндөрхангай - 100.5
Улаангом - 26.3	Наранбулаг - 123.6	Ховд - 96.4
Өндөрхангай - 14.3	Хяргас - 122.9	Өмнөговь - 94.3
Зүүнговь - 13.1	Өндөрхангай - 109.2	Наранбулаг - 94.2
Сагил - 12.5	Малчин - 108.7	Цагаанхайрхан- 88.9
Дүнд эзлэх хувь- 50.3	Дүнд эзлэх хувь- 38.9	Дүнд эзлэх хувь- 35.9
Өсгөсөн сум- 14	Өсгөсөн сум- 14	Өсгөсөн сум- 13
Өсөлт бууралтын хувь- 107.0	Өсөлт бууралтын хувь- 102.3	Өсөлт бууралтын хувь- 103.7

Мал тооллогын 2019 оны дүнгээр нийт сүрэгт ямаа, адуу, үхрийн эзлэх хувь 0.1 пунктээр өсч, хонины эзлэх хувь 0.5 пунктээр буурч, харин тэмээний эзлэх хувь өмнөх оны түвшинд байна.

Зураг 18.1.3 Малын сүргийн бүтэц, бод мал

Зураг 18.1.4 Малын сүргийн бүтэц, бог мал




Нийт мал сүргийн 99.7 (3269.2 мянга) хувь нь амины аж ахуйд, 0.3 хувь нь (10.4 мянга) албан газарт ноогдож байна.

18.1.2 ХЭЭЛТЭГЧ МАЛ


1464.3 мянган хээлтэгч мал тоологдож, хээлтэгчийн тоо өнгөрсөн оноос 3.3 хувь буюу 47.3 мянгаар өссөн байна. Хээлтэгч малын тоо Завхан, Тариалан, Өлгий суманд 0.8 - 4.9 хувиар буурч, бусад сумдад 0.9 – 11.4 хувиар өсчээ.

Зураг 18.1.5 Хээлтэгч мал, мян.тол



Нийт сүргийн 44.6 хувь нь хээлтэгч мал байгаа бөгөөд үүнээс тэмээний 34.5, адууны 31.1, үхрийн 42.1, хонины 46.2, ямааны 44.6 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Зураг 18.1.6 СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



18.1.3 АМИНЫ МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

100 хүртэлх малтай өрх нийт малтай өрхийн 33.6 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 1.0 пункт, 201-500 толгой малтай өрх 0.1 пунктээр буурч, 101-200 толгой малтай өрхийн эзлэх хувь өнгөрсөн оноос 0.4 пункт, 501-с 999 хүртэл малтай өрх 0.5 пункт, 1000 – аас дээш малтай өрх 0.2 пунктээр тус тус өсчээ.

Нийт малтай өрхийн 6.1 хувийг 10 хүртэл малтай, 8.3 хувийг 11-30 хүртэл малтай, 6.7 хувийг 31-50 хүртэл малтай, 12.4 хувийг 51-100 хүртэл малтай, 24.3 хувийг 101-200 хүртэл малтай, 28.1 хувийг 201-500 малтай, 14.1 хувийг 501-ээс дээш малтай өрх тус тус эзэлж байна.

Хүснэгт 18.2 Иргэдийн малын бүлэглэлт, өрхөөр

Малын бүлэглэлт	2015	2016	2017	2018	2019
10 хүртэл малтай	679	775	745	754	794
11-30 малтай	1123	1191	1140	1148	1 084
31-50 малтай	952	1006	941	933	879
51-100 малтай	1686	1812	1672	1661	1 619
101-200 малтай	2962	3041	3114	3106	3 166
201-500 малтай	3398	3363	3609	3667	3 663
501-999 малтай	1038	1057	1271	1307	1 384
1000-1499 малтай	281	305	388	395	417
1500-2000 малтай	20	15	25	22	27
2001-ээс дээш	3	4	4	4	5
Дүн	12142	12569	12909	12997	13038

13.0 мянган мал бүхий өрх тоологдож өнгөрсөн оноос 41 өрх буюу 0.3 хувиар өсч, эдгээр мал бүхий өрхийн 57.8 хувь нь буюу 7.5 мянган өрх 200 хүртэл малтай өрх байна. Өнгөрсөн оноос 200 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 0.3 пунктээр өссөн байна.

Малчин өрхийн малын бүлэглэлт, ноогдох мал, толгойгоор

бүлэглэлт	өрхийн тоо	Ам бүлийн тоо хүн	нийт мал тоо толгой	Үүнээс				
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
10 хүртэл малтай	168	421	1 074	4	73	701	154	142
11-30 малтай	377	985	7 685	35	491	2 189	2 191	2 779
31-50 малтай	362	1 084	14 732	91	850	2 627	4 706	6 458
51-100 малтай	877	2 950	67 010	750	3 436	8 514	24 508	29 802
101-200 малтай	2 151	8 384	320 764	2 855	15 097	26 764	125 698	150 350
201-500 малтай	3 189	14 153	1 017 839	8 338	42 585	60 784	463 657	442 475
501-999 малтай	1 362	6 779	920 080	8 795	32 783	40 015	496 773	341 714
1000-1499 малтай	414	2 189	475 655	2 848	15 677	18 038	283 329	155 763
